

Хотын талаарх ойлголт, тодорхойлолтууд

МУИС-ийн ЭЗС-ийн Хүн ам зүйн 4 дүгээр
ангийн оюутан Л.Ариунболор

Удирдсан багш: МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ-ийн ахлах багш Т.Навч

Хотын талаар нэгдмэл, оновчтой ойлголттой б олох нь хотжилтоос үүдэн гарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх эхний, чухал алхам болох бөгөөд үүний тулд дэлхийн бусад орны туршилагыг судлах явдал чухал гэж үзэж байна.

Дэлхий дээр хотыг тодорхойлох үндсэн 4 аргыг ашигладаг. Үүнд: Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, газар нутаг, хүн амын харьцаа (нягтийл буюу төвлөрөл), эдийн засаг, нийгмийн байгуулалт зэрэг болно. Гэхдээ дэлхийн хэмжээнд хотыг тодорхойлсон нэгдмэл нэг тодорхойлолт байхгүй байгаа нь энэ аргуудыг бүх улс орон шууд авч хэрэглэх боломжгүйг харуулж байна. Иймээс ч улс орон бүр тухайн оронд хэрэглэж буй үндэсний хэмжүүрийг хэрэглэдэг байна.

Харин манай улсын хувьд хотыг Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд тодорхойлсон байдал ч, бусад хууль, тогтоомжуудтайгаа зөрчилдөж байна. Хуулийн заалтуудаас үзэхэд өнөөгийн Монголын хотуудын онцлог байдал дараах байдааар илрэч байна.

- *Хот, тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэг нэгжийнх нь нутаг дэвсгэрт оршидог.*
- *Хот, тосгон нь хуулиар олгосон нутаг дэвсгэргүй.*
- *Хот нь улсын, аймгийн зэрэглэлээсээ үл хамааран засаг захиргааны хувьд аль нэг аймаг суманд харьяалагддаг.*
- *Хот, тосгоны удирдлага нь засаг захиргааны үйл ажиллагаа явуулах эрхгүй.*
- *Засаг захиргааны үйл ажиллагаа явуулах эрх нь бүх шатны засаг даргад хадгалагдаж байдал. Хот гэдэг ойлголтыг улс орны хөгжлийн өнөөгийн шат, нийгмийн амьдралын бодит байдалд нийцүүлэн оновчтой, зөв тодорхойлж хараахан чадаагүй, ойлголтууд цэгцтэй биши байгаа нь хотын төлөвлөгөө, хяналтгүй өсөлт, зах нутгийн эзгүйдэл болон эдгээртэй холбогдон үүсч байгаа олон олон асуудлыг буй болгож байна.*

Хотжилтоос үүсч байгаа асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэхэд Монгол улсын хотжилтын өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэх, ингэхдээ дэлхийн бусад улс орны хотжилтын түвшинтэй харьцуулан судлах явдал чухлаар шаард агдаж байн а.

Хот гэдэг ойлголтыг манай улсын бодит нөхцөлд тохируулан зөв, оновчтой тодорхойлж хараахан чадаагүй байгаагаас хотжилттой холбогdon үүсэж байгаа олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учирч байна. Учир нь хотжилтын түвшин ямар байна вэ? гэдгээс хотын хүн амын үнэлгээ, төлөвлөлт ихээхэн хамаардаг. Үнэлгээ, төлөвлөлтийн чанар нь ямар тооцооллыг ашиглаж, хэрхэн тооцоолсон бэ? гэдгээс хамаардаг бөгөөд мэдээж тооцоолол нь нийт хүн ам болон хотын хүн амын тооноос шалтгаалдаг билээ. Иймээс юуны өмнө хотын хүн ам гэж юу вэ? ямар онцлог газрыг хот гэж ойлгох вэ? гэсэн эрх зүйн үндэслэлийг нэн түрүүн цэгцлэх шаардлагатай юм.

1990-ээд оны дунд үеэс эрчимтэйгээр нэмэгдэж байгаа Улаанбаатар хотын хүн ам зүйн болон эдийн засаг, нийгмийн хөгжил, хэт төвлөрлийг бууруулан, хот, хөдөөгийн ялгааг багасгах нь Монгол улсын хөгжил дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулах нь дамжигүй. Иймээс хотын талаар нэгдмэл, оновчтой ойлголттой болох нь хотжилтоос үүдэн гарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх эхний, чухал алхам

болов бөгөөд үүний тулд дэлхийн бусад орны туршилагыг судлах явдал чухал гэж үзэж байна.

Дэлхий дээр хотыг тодорхойлох үндсэн 4 аргыг ашигладаг ажээ. Үүнд:

1. Хүн амын тоо,
2. Газар нутгийн хэмжээ
3. Газар нутаг, хүн амын харьцаа /нягтишил буюу төвлөрөл/
4. Эдийн засаг, нийгмийн байгуулал зэрэг болно.

Улс орнуудын одоогийн мөрдөж байгаа хотын тодорхойлолтууд нь дээрх үзүүлэлтүүдийг тэр бүр бүрэн багтаадаггүй, тоо мэдээлэл хангалттай бусаас шалтгаалан зөвхөн хүн амын тоог гол болгох явдал түгээмэл ажиглагдаж байна.

Аливаа зүйлийг хэмжих нэгдсэн нэг шалгуур байх нь асуудлыг хөнгөвчилдөг ч хот суурин газрыг тодорхойлсон оновчтой, тодорхой дэлхийн хэмжээний нэгдсэн нэг стандарт гаргах явдал маш хүндрэлтэй, боломжгүй асуудал юм. Тухайлбал, 5 000 хүнтэй хөдөөгийн тосгоныг хот гэж нэрлэдэггүй ч, 2 500 хүнтэй жуулчны бааз, эсвэл раашан сувилын газрыг хот гэж авч үзэх явдал байдаг. Мөн хотын хүн амын доод хязгаарыг зааж, 5 000-аас багагүй хүн амтай сууринг хот гэнэ гэвэл Хятад, Энэтхэг зэрэг хөдөө нутагтаяа ч хүн ам ихтэй улс оронд зөвхөн хүн амын тоогоор бус хотын бусад шалгуур үзүүлэлтийг бий болгох шаардлага гарч ирэх нь зайлшгүй. Тийм учраас улс орон бүрийн албан ёсны статистикийн тодорхойлолтыг ашигладаг, тухайн улс оронд тохирсон шалгуураар хотыг тодорхойлох нь зохимжтой байдаг.

НҮБ-аас жил бүр гаргадаг "Хүн ам зүйн жилийн эмхэтгэл" номын 2001 оны хэвлэлийн хүснэгт 6-д дэлхийн 226 улсын хотын тодорхойлолтын талаарх мэдээлэл хэвлэгдэжээ. Энэхүү мэдээлэлд хүн ам зүйч Мартин Брокерхоф шинжилгээ хийж "Хотжиж буй ертөнц" гэсэн өгүүлэлдээ шигтгээ болгон оруулснаас үзвэл¹⁸: Тус мэдээлэлд орсон 226 улсын тэн хагас нь хотыг тодорхойлоходоо засаг захирагааны нэгжийн асуудлыг чухалчилсан байна. Өөрөөр хэлбэл, улсын болон аймгийн, эсвэл мужийн нийслэл бол хотын оршин суугчдаас бүрдэх ёстой ажээ. Бусад 51 орны хувьд хот, хөдөөгийн хүн амыг ялгахдаа тоо хэмжээ ба нягтишаар нь авч үзсэн байхад 39 улс орон хотыг тухайн газар нутгийн эдийн засгийн үйл ажиллагаагаар тодорхойлжээ. Гэтэл 22 улс хотын тухай ямар ч тодорхойлолтгүй байна. Харин 8 улс орны хүн ам бүгдээрээ хотын хүн ам, эсвэл дандаа хөдөөгийн хүн ам байдаг байна.

Улс орнууд хотыг хэрхэн тодорхойлж байгааг жишээ болгон Хойд Америкийн 3 улсаар авч үзвэл:¹⁹

АНУ-ын Тооллогын товчооноос хийсэн 2000 оны тооллогод тооллогын тойргууд болон тойргийн бүлгүүд нь дор хаяж нэг кв. миль газарт 1000 хүн ногдох хэрэгтэй бөгөөд түүнийг тойрсон эргэн тойрны газар нутагт нэг кв. миль газарт 500 хүн ногдож байх ёстой юм байна. Энэ шалгуурыг хангасан тохиолдолд дээрх газар

¹⁸ Martin P.Brockerhoff. An Urbanizing World. "Population Bulletin". September 2000. Vol. 55, No.3. Шигтгээ 1.

нутгууд хотын нутаг дэвсгэрт хамарагдах ажээ. Дор хаяж 2500 хүн амтай газрыг хот гэж нэрлэж байгаа бөгөөд хотын нутаг дэвсгэр болон хот маягийн суурин гэж нэрлэгдээгүй бусад бүх газрыг хөдөө гэж тооцдог юм байна.

Тэгвэл, Канад улсын хувьд Канадын Статистикийн газраас явуулсан 1996 оны тооллогоор "хот газар" /хотын бүс/, "хотын нутаг дэвсгэр" /хотын бүс/ гэдгийг дор хаяж 1000 хүн амтай, хүн амын нягтишил нь нэг кв. миль газарт 1000 хүн ногдож байхаар авч үзсэн байна.

Мексикийн хувьд 2500-гаас дээш хүн амтай ямар ч газрыг "том хот", "хот маягийн суурин" /жижиг хот/ гэж ялган тооцдог. Гэхдээ Канадын адил хотын бүс гэдгийг дор хаяж 100 000 оршин суугчтай байхыг шаарддаг ажээ.

Тийнхүү АНУ, Канад хоёр хүн амын тоо, нягтишил хоёрыг үндэслэн хотыг тодорхойлж байхад Мексикийн хувьд зөвхөн хүн амын тоо хэмжээг харгалzan үзэжан ангилж байна. Эдгээрт нийгэм, эдийн засгийн ямар ч шинж чанарыг ашиглаагүй байна. Энэ бүгдээс үзэхэд дэлхийн хэмжээнд хотыг тодорхойлсон нэгдмэл нэг тодорхойлолт байхгүй байдаг нь харагдаж байна. Иймээс ч улс орон бүр тухайн оронд хэрэглэж буй үндэсний хэмжүүрийг хэрэглэдэг байна.

Харин манай улсын хувьд "хот"-ыг "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" хуульд тодорхойлсон байдаг ч, бусад хууль, тогтоомжуудтай хэрхэн зөрчилдөж байгаа талаар авч үзье.

Монгол улсын хотын эрх зүйн байдал нь 1992 онд батлагдсан "Монгол улсын үндсэн хууль", 1994 онд батлагдсан "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай" хууль, мөн онд батлагдсан "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай" /1995, 2003 онуудад нэмэлт өөрчлөлт орсон/ хууль, 1992 онд батлагдсан "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" /1994, 1996, 1999, 2000, 2003 онуудад нэмэлт өөрчлөлт орсон/ хууль болон "Статистикийн тухай" хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Үндэсний статистикийн газраас "Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого"-д зориулан тодорхойлсон "Хотын хүн ам, өрх" тодорхойлолт, Монгол улсын тосгон/хот маягийн суурингийн жагсаалтаар зохицуулагдаж байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар суурин газруудыг хот болгох нэгдмэл хэмжүүрийг 1960 онд тогтоосон байна. Энэ нь манай орны амьдралд хотын эзлэх байр суурь өсч буйг харуулсан анхны хуульчилсан баримт бичиг юм. 1973 онд орон нутгийн харьялалтай хотын хэмжүүрийг хянан үзэж 6 мяняас доошгүй хүн амтай, тэдгээрийн олонхийн орлогын эх үүсвэр нь цалин хөлс болдог, засаг захиргаа, үйлдвэр, соёлын нэгжүүд бүхий суурин газрыг хот болгож байхаар заасан.

Харин 1983 онд энэ зарлигийг хүчингүй болгосноор манай улсад суурин газрыг хотод тооцох нэгдсэн журам байхгүй болж, арван жилийн дараагаас буюу 1994 оноос мөрдөгдөж буй "Хот, тосгоний эрх зүйн байдлын тухай" хуульд зааснаар "Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн" гэж тодорхойлсон. Харин тосгон гэсэн

тодорхойлолтондоо хүн амын тоог 500-гаас доошгүй байхаар зааж өгчээ. Энэ нь нутаг дэвсгэр уудам, хүн ам цөөтэй манай орны хувьд хатуу хэмжүүр гэж үзэж байна.

Гэсэн ч хүн амын тооны шалгуур нь зөвхөн тоо төдий байгаа бөгөөд энэ шалгуурыг давсан ч ”хот” гэж тооцогдож байгаа ямар ч газар нутаг байхгүй. Үндэсний статистикийн газраас хот маягийн сууринг өөрсдийн шалгуураар ангилахдаа ч тосгодын хүн амын тоог гол шалгуур болгоогүй бололтой. Үндэсний статистикийн газраас 22 тосгонг хот маягийн суурин гэж ангилсан ба энд 500 хүрэхгүй хүн амтай тосгод олон байна. Харин 15 000-аас их хүн амтай тосгон байгаа эсэхийг мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан мэдэж чадсангүй.

Статистикийн тухай хуулийн Үндэсний статистикийн газар, түүний бүрэн эрх гэсэн 12 дугаар зүйлийн 3-ын 2-т ”албан ёсны статистикийн мэдээлэл, судалгаа, тооллогын үзүүлэлт, аргачлал, зааврыг батлах, зөвшөөрөх, мэдээлэх хугацааг тогтоох”, тус зүйлийн 3-ын 5-д ”статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх” гэж тус тус заасны дагуу, өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд ”хотын хүн ам” гэдгийг тодорхойлжээ.

ҮСГ-аас тодорхойлж ”Хүн ам, орон сууцны 2000 оны үндэсний тооллого”-д ашигласан тодорхойллын дагуу аймгийн төвүүдийг автоматаар хотод тооцсон. 2000 оны байдлаар аймгийн төвүүдийн хүн ам хэд байсныг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Аймгуудын хүн амын тоо, 2000

Бүлэглэсэн хүн ам	Тоо	Хувь	Өсөн нэмэгдэх давтамж
15 000 хүртэл	4	19.0	19.0
15 000-30 000	14	66.7	85.7
30 001-60 000	1	4.8	90.5
60 000+	2	9.5	100.0
Нийт	21	100.0	

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын улсын дүн

Зарим хотуудын хүн ам, тухайлбал, Булган /12 684/, Дундговь /14 517/, Өмнөговь /14 050/, Төв /14 837/ аймгуудын хүн ам 15 000 мянгад хүрэхгүй байгаа ч нийт хотуудын /аймгийн төвүүдийн/ ихэнх нь /81.0 хувь/ 15 000 ба түүнээс дээш оршин суугчидтай байгаа юм.

Гэтэл эдгээр хотыг Улсын их хурлаас 1994 онд баталсан ”Аймаг, сум байгуулах тухай, зарим хотын хороог татан буулгах, зарим хот, хороодыг сумдад нэгтгэх тухай” тогтоол батлагдан гарснаар аймаг, аймгийн төв, сум болгон өөрчилсөн. Ингэснээр 83271, 71525 хүн амтай /хүн ам, орон сууцны 2000 оны тооллого/, хүнд, хөнгөн үйлдвэр хөгжсөн Дархан, Эрдэнэт хотуудыг аймгийн төв гэх үү, хот гэх үү, сум гэх үү гэсэн асуулт тулгарах болсон. Мөн аймгийн төвүүдийг бусад жижиг тосгон, сууринтай, аймгийн төвийн хүн амыг хөдөөгийн хүн амтай адилтган авч үзэх нь хот, хөдөөгийн ялгааг бүдгэрүүлсэн, түүгээр үл барам хотын хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлсөн, бусад хууль эрх зүйн акттай зөрчилдсөн тогтоол болсон гэж үзэж байна.

”Хот тосгоны эрх зүйн байдлын тухайн” хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа болохоор сум гэж нэрлэгдэж байгаа хуучин хотын статустай байсан орон нутгийг ”хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжөөгүйгээс” тухайн шалгуурыг давахгүй байгаа юм байх гэж таамагламаар байна. Учир нь ”хот бүрдүүлэгч дэд бүтэц” гэдэгт юуг хамруулах вэ гэдгийг тодорхой зааж өгөөгүй. Мөн тус хуулийн 4 дүгээр зүйлийн нэгд ”хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна”, мөн зүйлийн хоёрт ”50000-аас дээш /шаардлагатай гэж үзвэл 50 000 хүртэл/ оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно” гэжээ. Гэвч 2000 оны байдлаар Орхон аймаг 71 525 хүнтэй, Дархан-Уул аймаг 83 271 хүнтэй байгаа бөгөөд эдгээр аймгийн нийт хүн амын 95.5, 79.0 хувь нь хотын хүн ам гэж тоологдсон боловч улсын зэрэглэлтэй хот ч биш, аймгийн сумын статустай байгаа юм.

1994 онд ”Нийслэлийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдан гарсан. Энэ хуульд дараах асуудлуудыг тусгажээ. Үүнд:

- Нийслэл нь хуулиар тусгайлан олгосон онцлог чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг, захиргаа, нутаг дэвсгэр, нийгмийн цогцолбор бөгөөд тусгай статус бүхий хот мөн.
- Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амыг хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүдиээс дагуул хот (алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон) -той байж болно.

Улаанбаатар хотод хүн амын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн зохисгүй хэт төвлөрөл үүсээд байгаа энэ үед дагуул хоттой болох нь төвлөрлийг сааруулахад тус нэмэртэй байх нь дамжигүй боловч Налайх, Багануур гэсэн алслагдсан дүүргүүдээс өөр дагуул хот гэж нэрлэхээр хот байхгүй юм. Мөн эдгээр дагуул хотуудын байршил ч гэсэн оновчтой зохицуулагдаагүй, тодруулбал, хот дагуул хотуудын хоорондын газар нутаг Төв аймгийн газар нутаг байгаа учраас хотын зааг нутгийг ялган тодорхойлох, тэр бүү хэл нягтралыг зөв тооцоход ч хүндрэлтэй байгаа юм.

Дээрх бүхий зөрчилтэй байдал, тухайлбал Дархан, Эрдэнэт зэрэг хотуудыг аймгийн төвийн сум болгосон нь Үндсэн хуулийн тодорхой заалтуудаас үүдэлтэй юм. Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт ”Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана, 4 дүгээр бүлгийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ”Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.”, Мөн зүйлийн 2 дахь хэсэгт ”Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн заалтуудад нийцүүлэн нийслэл Улаанбаатараас бусад хотыг аймгийн төв, эсвэл тосгон болгон өөрчилжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт ”Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж

заасан нь өнөөгийн хот, тосгоны өмнөх тогтолцооны хот, тосгодаас ялгагдах гол онцлог болдог. Энэ онцлог нь хот, тосгод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болдоггүйд оршино.

Дээрх хуулийн заалтуудаас үзэхэд өнөөгийн Монголын хотуудын онцлог байдал дараах байдлаар илэрч байна.

- *Хот, тосгон нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн аль нэг нэгжийн нь нутаг дэвсгэрт оршидог.*
- Хот, тосгон нь хуулиар олгосон нутаг дэвсгэргүй.
- Хот нь улсын, аймгийн зэрэглэлээсээ үл хамааран засаг захиргааны хувьд аль нэг аймаг суманд харьялагддаг.
- Хот, тосгоны удирдлага нь засаг захиргааны үйл ажиллагаа явуулах эрхгүй.
- Засаг захиргааны үйл ажиллагаа явуулах эрх нь бүх шатны засаг даргад хадгалагдаж байдаг.

1994 онд УИХ-ын 32 дугаар тогтоолоор Дархан, Эрдэнэт, Чойр хотуудыг аймгийн төв болгон өөрчлөж, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгуудыг шинээр байгуулснаар нийт 21 аймагтай болсон.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хэр оновчтой хуваагдсан эсэхийг шалгах шалгуурууд байдаг бөгөөд түүнийг багцлан үзвэл²⁰:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд нь удирдлагын түвшин бүрд харилцан чанд уялдсан нэгдмэл байдлыг хангасан байх
- Бүс нутгийн хөгжлийг нийгэм, эдийн засаг, экологийн иж бүрэн хандлагаар үр ашигтай явуулах нөхцлийг бүрдүүлсэн байх
- Засаг захиргааны нэгжүүд, тэдгээрийг бүрдүүлэгч хэсгүүд нь удирдлагын чиг үүрэг, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хялбар дөхөм байхаар зохион байгуулагдсан байх
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламж нь бүхэлдээ бүс нутгийн болон улс орны чанартай томоохон зорилтыг хэрэгжүүлэн байгаль, эдийн засгийн нөөц, боломжоор хангагдсан байхыг шаарддаг.

Манай орны хувьд одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд нь дээрх шалгууруудыг бүрэн хангаж чадахгүй байгаа төдийгүй улс орноо одоогийнхоос илүү хөгжүүлж, дэлхийн хөгжилтэй улсуудын хэмжээнд хүргэхэд учир дутагдалтай байгаа бөгөөд хуучин хэлбэрээрээ цааш явах нь хүндрэлтэйн дээр хөгжих явцад зарим талаар саад учруулж байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийг шинээр бий болгох, татан буулгах, өөрчлөх зэрэг асуудал нь зөвхөн ганц хүний эрх ашигийн төлөөх зүйл биш бөгөөд энэ асуудал нь өөрөө маш эмзэг асуудал юм байна. Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг

²⁰ Удирдлагын Академи, Магистрын ажил, "Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан боловсронгуй болгох нь", Н.Ууганчимэг, УБ.,2005

өөрчлөх, татан буулгах, шинээр байгуулах зэрэг асуудлыг авч үзэхэд эрх зүйн зарим заалтууд бүдэг байгаа төдийгүй, хэрхэн шийдвэрлэх арга зам ч тодорхойгүй байна.

Энэ бүгдээс үзэхэд: Хот гэдэг ойлголтыг улс орны хөгжлийн өнөөгийн шат, нийгмийн амьдралын бодит байдалд нийцүүлэн оновчтой, зөв тодорхойлж хараахан чадаагүй байгаагаас үүдэлтэй олон төвөгтэй асуудал тулгарч байна. Үндсэн хуулийн тодорхой заалтуудаас эхлээд энэ асуудлыг нэгэн мөр цэгцтэй бөгөөд оновчтой шийдвэрлэхэд хүндрэл учруулж буй зүйл олон байгаа юм. **Өөрөөр хэлбэл**, хууль нь хуулиа хорьж байгаа учир шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал бүрэлдээд байна.

Мөн холбогдох хуулиудын нэр томъёо тэр бүр цэгцрээгүй, хууль зүйн үүдиэс зохих журмын дагуу тодруулан тайлбарлаагүй зүйл заалт олон байгаа нь тэдгээр хуулийг дагаж мөрдөхгүй байх, улмаар өөр хоорондоо сайтар уялдаагүй олон хууль, журам батлагдан гарах нөхцөл болж байна.

□Хот□ болон түүнтэй холбогдох ойлголтууд цэгцтэй биш байгаа нь хотын төлөвлөгөө, хяналтгүй өсөлт, зах нутгуудын эзгүйдэл болон эдгээртэй холбогдон үүсч байгаа олон асуудлыг буй болгож байна.

Хотжилтоос үүсч байгаа асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэхэд Монгол улсын хотжилтын өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэх, ингэхдээ дэлхийн бусад улс орны хотжилтын түвшингтэй харьцуулан судлах явдал чухлаар шаардагдаж байна.

Ашигласан материал

1. Г.Совд, С.Жанцан, Н.Жанцан, Ж.Амарсанаа, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*. УБ, 2000
2. Сандааг-Очир М., *Нутгийн удирдлага*. УБ., 2004
3. Сономдагва Ц., *Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэл*. УБ., 1996
4. *Demographic Yearbook*. 2001
5. *Монгол улсын Засгийн газар, Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэд шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх нийтлэг журам*. Засгийн газрын 1996 оны 47 дугаар тогтоолын хавсралт
6. Martin P. Brockerhoff, *An Urbanizing World. Population Bulletin. A Publication of the Population Reference Bureau*. Vol.55. №3. 2000. September
7. National Intelligence Council. *Global trends 2015: A dialogue about the future with nongovernment experts*. Langley, Virginia, National Foreign Intelligence Board, Dec. 2000
8. Навч Т., *Хотын шилжилт*. Лекцүүд.
9. Тогтвортой хөгжил. *Монгол Улсын ХХI зууны тогтвортой хөгжил төсөл*. УБ., 2003
10. УИХ, *Нийслэлийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль*, 1994.07.05.
11. УИХ, *Монгол Улсын Үндсэн хууль*. УБ, 1992
12. УИХ, *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль*. 1992.04.05.
13. УИХ, *Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль*, 1994.02.27.
14. Ууганчимэг Н., *Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг бүсчилсэн хөгжлийн узэл баримтлалтай уялдуулан боловсронгуй болгох нь*. Удирдлагын академи. Магистрын ажил. УБ., 2005
15. УИХ, *Статистикийн тухай Монгол Улсын хууль*.
16. Хүн ам, орон сууцны тооллого. Монгол Улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого дээр үндэслэсэн судалгаа. ҮСГ. НУБХАС, УБ., 2002
17. World Development Indicators, 2000